



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
УЛСЫН БАЙЦААГЧИЙН АЛБАН ШААРДЛАГА**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр,
Утас/факс: 32-90-84

2015.3.03 № 23
таний _____-ны № _____-т

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.АНГАР ТАНАА**

Үүрэг даалгавар өгөх тухай

1. Үүрэг даалгаврын товч утга

Хорооны 2015 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 67 дугаар тогтоолоор Хөрөнгийн бирж дээрх үнэт цаасны арилжааны төлбөр, тооцоог тухайн арилжааны дараагийн ажлын өдөрт багтаан гүйцэтгэх үүргийг “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦТТХТ” ХХК-иудад тус тус өгсөн болно.

2. Үүрэг даалгавар, түүний эрх зүйн үндэслэл

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.1.4-т заасан эрхийн хүрээнд дараах үүрэг даалгаврыг өгч байна. Үүнд:

1/ Хорооны 2015 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 67 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд эрх зүйн зохицуулалтын ажлууд бүрэн хийгдэж дууссан тул өөрийн байгууллага дээрх холбогдох системийн тохируулгыг хийж, 2015 оны 3 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн үнэт цаасны арилжааны төлбөр, тооцоог T+1 горимд гүйцэтгэх.

3. Үүрэг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ

Үүрэг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.1.5-д зааснаар захиргааны арга хэмжээ авах нөхцөл бүрдэхийг анхааруулж байна.

УЛСЫН БАЙЦААГЧ:



А.АВИР

000352